

**Лувсанноровшаравын төвд хэлээр зохиосон
долоон боть сүмбүмийн гарчиг,
төгсгөлийн үгийн тухайд**

Д. Бүрнээ (МУИС)

Лувсанноровшаравын сүмбүмийн дөрвөн зүйлийн гарчгийг олж үзлээ. Эдгээр нь бичмэл болон барын, хураангуй ба дэлгэрэнгүй хэдэн янз байна. Тэдгээрийг латин үсгийн цагаан толгойн дарааллаар А, В, С, D хэмээн дугаарлавал А гарчиг¹ 54 зохиол, Б гарчиг² 58 зохиол, С гарчиг³ 60 гаруй зохиол, D гарчиг⁴ 54 зохиол бүртгэгдсэн байна. А гарчигт долоон ботийн дотор орсон зохиолын нэрийг бүрэн бичиж, хуудасны тоог тавьжээ. Б гарчигт зохиолын нэрийг товчлон бичиж, хуудасны тоог тавьсанаас гадна Лувсанноровшараваас тухайн зохиолуудын уншлагын эш, сайтар сонссоны үндсийг уламжлан авагсдын дэс дарааллыг гаргасан байна. В гарчигт хамгийн олон зохиол орсоноос гадна бүтцийн хувьд Б гарчгаас ялгаатай нь тахилын шүлэгтэй ажээ. Тахилын шүлэгт бичсэн нь:

“Богд Лувсандагвын судар дандарын номын ёсоор

Бодь шавь нарын эгээрлийг хангах оройн чандмани мэт

Бодтой номлох, сонсох, дэлгэрүүлэх гуравт тотгоргүй билигт

Богд Зонхов таны өлмий дор сөгдөн мөргөмүй би” хэмээн шарын шашныг үндэслэгч Зонхов Лувсандагвыг магтан шүлэглээд “үүнд шар малгайтны өнө ёсыг баригч дээд төрөлхт Сумадиманипражня буюу бус нэрээр дээд Мандширын зарлигаар Чин сүжигт номун ханд дуудагдах бээр зохиосон сүмбүмийн гарчиг хийгээд үндсийн үе зэргийг

¹ "Shes bya'i mdzod", Бээжин, 1989.

² "Лавайн эгшиг" 1998, 1, "Чин сүжигт номун хан Сумадиманипражнягийн сүмбүмийн ботийн гарчиг" 4 хуудас (төвд хэлээр).

³ Л.Хүрэлбаатарын хувийн номын цуглуулгад буй, Чин сүжигт номун хан Сумадиманипражнягийн долоон боть сүмбүмийн гарчиг хийгээд уншлагын эшийг сайтар авсаны үндсийн үе зэрэг (төвд хэлээр).

⁴ УННС-ийн төвд номын хөмрөгт буй Чин сүжигт номун хан Лувсанноровшаравын сүмбүмийн 3524 тоот дансны бүртгэлтэй "dkar chag bzhugs so" хэмээх гарчиг.

байгуулсанаа” дурджээ. D гарчигт нийт 54 зохиолын нэрийг жагсаасан байна.

Лувсанноровшаравын сүмбүмийн гарчгуудаас үзвэл нийт долоон ботид 54-60 зохиолыг жагсаан бичжээ. Үүнийг боть тус бүрээр авч үзвэл: Га буюу 1-р ботид 25-27 зохиол, Ха боть буюу 2-р ботид 27-30 зохиол, Гагаас Ча боть буюу 3-6-р ботид 4 боть нэг зохиол, төгсгөлийн Жа буюу 7-р ботид нэг, нийт 54-60 зохиол орсон байна. УННС-ийн төвд номын хөмрөгт хадгалагдаж буй Лувсанноровшаравын 7 боть зохиолын төгсгөлийн үгийг ажиглавал дараах мэдээллийг тэмдэглэсэн байна. Үүнд:

I. Зохиолоо бичих болсоны учир

II. Зохиолоо хэрхэн бүтээсэн

III. Хаана, ямар хийдэд бүтээсэн

IV. Хэзээ бүтээсэн

V. Хэн бүтээсэн, бичээч нь хэн болох

VI. Зохиолын тус эрдэмийг тэмдэглэсэн байна. Эдгээрийг тус бүрд нь авч үзвэл:

Нэг. Тухайн зохиолоо бичих болсоны учир

Лувсанноровшарав ихэнхи зохиолоо олны захиалгаар бичжээ. Үүнд лам хувраг болон төрийн ихэс ноёдын гуйлт голлож байна. Зохиогч олонхи бүтээлээ тойн Доржжалцан, ордосын бэйл Ойдовжамц, гэлэн Лувсанжалцан нарын хүсэлтээр бүтээжээ. Доржжалцан бол бурханы шашинд чин үнэнч бөгөөд Лувсанноровшаравын номын ах, сэтгэл номхон, амарлингуй, сүсэг төгс, буяны зүгт их хичээнгүй нэгэн байсныг төгсгөлийн үгэнд онцлон тэмдэглэжээ. Тухайлбал: “Лам хийгээд Мандширыг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох” хэмээх зохиолыг “Ламд үл хагаслах сүсэг төгөлдөр буяны зүгт их хичээнгүй, сэтгэл номхон, сайтар амарлисан Доржжалцан бээр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бичлээ хэмээсэн бол “Ялж төгс нөгчсөн Цэвэгмэдэд шүтэж насны үрэл бүтээх зан үйл насан ба буян арвитгах санааг арвижуулах чандмани эрдэнэ” нэрт зохиолыг “лам хийгээд чухал дээд гурвыг үл ялгах сүсэг төгөлдөр өөрийн номын ах Доржжалцан бээр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бүтээв гэжээ”⁵. Доржжалцангийн хүсэлтээр “Сайнгалавын мянган бурханы мөргөл, тахил ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулах рашааны их хур буухуй”, “Лхашдилдүвийн даяаны эрхийг үргэлжид авахын дараалал рашааны хур буухуй” зэрэг номыг бүтээжээ⁶.

Мөн энэ хүн таалал төгсөхөд “өөрийн номын ах Доржжалцан амарлингуй номын чанарт болсон дөчин есөн хоног” “Эрлэгийн эзэн

⁵ Bla ma dang 'jam dbyangs zung 'brel gyi bla ma'i mal 'byor byin rlabs myur 'jug ces bya ba bzhugs.

“Лам хийгээд Мандширийг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох”, 8а., дансны дугаар 3527

⁶ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi my u gu 'phel bar byed pa'i bdud rts'i'i char chen zhes bya ba ' bzhugs

“Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур”, 41а-41b, дансны дугаар 3525,

lha bzhi dril sgrub-kyi ting nge 'dzin gyi dbang rgyun-du blang-ba'i rim-pa bdud rts'i'i char 'bebs zhes bya ba bzhugs

“Бэгэ, Жамсран сахиуст сан тахил өргөх ёсон санасан бүхэн бүтэг хэмээх оршив”, 7а., дансны дугаар 3567.

бээр барьсан өмнийн үүдний зан үйл тоилох мөр ном бүтээсэнээ дурджээ.⁷

Ордосын бэйл Ойдовжамц Лувсанноровшаравт нэлээд ном захиалжээ. Энэ хүн Чингисийн удмын, тухайн цаг үедээ нэр хүндтэй нэгэн байжээ. Тэрээр дээдийн номд сүжигт, хичээнгүй, тийн шинжлэл дээд нэгэн байсан ба түүний хүсэлтээр "Хутагт их тоилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц, түйтгэр бүгдийг машид угаах рашааны их хур"⁸, "Лам хийгээд Мандширийг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох"⁹, "Бацаг сахихын тус эрдэм товч хураангуй сүсгийн ногоо"¹⁰, "Дөрвөн зуугийн зан үйл шулмасын үйлийг сайтар ялгуусан"¹¹ зэрэг номыг бүтээжээ. "Хутагт их тоилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц, түйтгэр бүгдийг машид угаах рашааны их хур" хэмээх номыг хэрхэн бүтээсэн тухайд "үүнийг хүчний хүрдэн орчуулагч Чингис хааны удам угсааны хүчин хийгээд олз учралын хотол чуулган төгссөн ордосын Ойдовжамц бээр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дуртгасанд энэ зан үйл тарнийн ёс лугаа барилдлага их хэрэггүй байсан боловч дурдсан таалал лугаа нийцүүлэн үйлийн дандар лугаа барилдуулваас гэмгүй бус уу хэмээн санаж" бүтээсэн гэх буюу "ариун (цамба) хүний дүрст хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны овог язгуурт мэндэлсэн сүсэг хийгээд учрал хотол чуулсан ордосын бэйл Ойдовжамц бусдад туслахыг таалсан үлэмж санаагаар бүхнээс гуйж энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигласанд" бүтээсэн хэмээжээ.¹² Эндээс үзвэл Лувсанноровшарав тухайн хүмүүсийн захиалсан зан үйлийн зарим номыг тарнийн ёстой хослуулан хялбаршуулан бичвэл олны хэрэгцээнд нийцнэ гэж үзсэн байна.

Цаашилбал бандид цорж Лувсанжалцангийн хүсэлтийг анхааран авчээ. "Эрлэгийн эзэн бээр барьсан өмнийн үүдний зан үйл тоилох мөрийн гэгээн зул" хэмээх оршив"...хэмээх үүнийг мэргэн, тойн, сайн гурвын эрдэм төгөлдөр Билэг арвижуулах сүмийн Даа лам бандид цорж Лувсанжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд бүтээсэн гэжээ.¹³ Бандид цорж Лувсанжалцан бол Билиг арвижуулах сүмийн даа лам байсан ба энэ хүний гуйлтаар "Суртгаалыг огоот

⁷ gshig-po rjes 'dzin lho sgo'i cho ga thar lam gsal-ba'i sgron me zhes bya-ba bzhugs/

"Эрлэгийн эзэн бээр барьсан өмнийн үүдний зан үйл тоилох мөрийн гэгээн зул", 23b-24a., дансны дугаар 3551.

⁸ 'phags pa thar pa chen po phyogs su rgyas pa'i mdo sde 'don pa'i cho ga sdig sgrib thams cad rab tu 'khru bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs so.

"Хутагт эх тоилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц түйтгэр бүгдийг машид угаан үйлдэх рашааны их хур", 18b-19a., дансны дугаар 3526.

⁹ bla ma dang 'jam dbyangs zung 'brel gyi bla ma'i mal 'byor byin rlabs myur 'jug ces bya ba bzhugs.

"Лам хийгээд Мандширийг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох", 8a., дансны дугаар 3527.

¹⁰ bsnyen gnas bsrungs pa'i phan yon mdor bsdu pa dad pa'i my u gu zhes bya ba bzhugs.

"Бацаг сахисаны тус эрдэм товч хураангуй сүсгийн ногоо", 5b-6a, дансны дугаар 3530.

¹¹ brgya bzh'i'i cho ga 'dud-las nam rgyal zhes bya-ba bzhugs/

"Дөрвөн зуугийн зан үйл шулмасын үйлийг сайтар ялгуусан", дансны дугаар 3557.

¹² 'phags pa thar pa chen po phyogs su rgyas pa'i mdo sde 'don pa'i cho ga sdig sgrib thams cad rab tu 'khru bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs so.

"Хутагт эх тоилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц түйтгэр бүгдийг машид угаан үйлдэх рашааны их хур", 18b-19a., дансны дугаар 3526.

¹³ gshig-po rjes 'dzin lho sgo'i cho ga thar lam gsal-ba'i sgron me zhes bya-ba bzhugs/

"Эрлэгийн эзэн бээр барьсан өмнийн үүдний зан үйл тоилох мөрийн гэгээн зул", 23b-24a., дансны дугаар 3551.

судалсан зан үйлийн санваарыг хичээн баясгагч"¹⁴, "Догшин чагдорын үйлийн чуулган"¹⁵, "Ерөөлийн хураангуй ямар мэт үйлдэх ёсны тус амгалангийн үүдийг нээхүй"¹⁶, "Цогт очирьг сайтар дарах зан үйл тус амгалангийн дээд соёрхол сампэлноров хэмээх оршив"¹⁷, "Эрлэгийн эзний барьсан өмнийн үүдний зан үйл тонилох мөрийн гэгээн зул"¹⁸, "Гүн хийгээд аугаа дээдийн номын товьёог тодорхой зул хэмээх оршив"¹⁹ зэрэг номыг бүтээжээ.

Үүнээс гадна их унзад Лувсанчүлтэм, гэлэн Лувсангомбо, гэлэн Ишзундуй, мэргэн цорж Гэндэнсамбуу, тойн Лувсандаржаа, гэнэн Лувсандампэл, аграмба Содномданзан нарын лам хувраг нарын хүсэл гуйлт хийгээд ноён Балдан, Жамьяндорж ван, ноён Ринчинжамц, ноён Самдан, Жамьяндорж вангийн хүү Цэрэндорж, Далай цоохор бэйл, далай Чойнхор бэйл Намжалцэсрүн, далай ван Дашпэлийн хөвгүүн ноён хутагт нарын гуйлтаар олон зохиолоо туурвижээ.

Ном бүтээхийг хүссэн хүмүсийн гуйлтыг ажиглавал зарим нь зарлигаар дурдсан, зарим нь тухайн зохиолыг амар хялбар, гарын авлага болгож бичихийг, зарим нь дэлгэрүүлж бичихийг, зарим нь бусдад буян бодож бичихийг хүссэн байна. Тухайлбал "Цогт очир Жигжидийн үүднээс зарлигийг сахих ёсон" хэмээх үүнийг хүрдэн орчуулагч Чингис хааны үндсэнд мэндэлсэн бөгөөд сүсгийн хүчин лүгээ төгс эрдэнэ ноён цорж Сандаг бээр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд"²⁰ гэх буюу "Тойн эх Гүрүгүвийн бүтээлийн арга шидийг түргэн дуудах төмөр гох" хэмээх үүнийг ариун хүмүний дүрст хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны язгуурт мэндэлсэн бөгөөд сүсэг хийгээд олз учрал хотол төгссөн Жамьяндорж ван энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд бүтээсэн гэжээ. Ихэс ноёд хүндэт лам нарын хүсэл гуйлтыг зарлигт бодож бүтээсэн нь илт байна.²¹

¹⁴ bslab pa yongs su sbyong ba'i cho ga sdom brtson dgyes byed ces bya ba bzhugs.

"Суртгаалыг огоот судалсан зан үйлийн санваарыг хичээн баясгагч", 26b-27a., дансны дугаар 3529.

¹⁵ rhyag rdor gtum po'i las tshogs bzhugs.

"Догшин чагдорын үйлийн чуулган", 4b., дансны дугаар 3536

¹⁶ bsdo-ba bsdus-pa ji ltar bya tshul phan bde'i sgo 'byed ces bya ba bzhugs-so/

"Ерөөлийн хураангуй ямар мэт үйлдэх ёсны тус амгалангийн үүдийг нээхүй", 4a., дансны дугаар 3554.

¹⁷ dpal rdo rje nam-par 'joms-pa'i cho ga phan bde'i mchog stsol bsam 'phel nor bu zhes bya ba bzhugs

"Цогт очирьг сайтар дарах зан үйл тус амгалангийн дээд соёрхол сампэлноров хэмээх оршив", 39b., дансны дугаар 3555.

¹⁸ gshig-po rjes 'dzin lho sgo'i cho ga thar lam gsal-ba'i sgron me zhes bya-ba bzhugs/

"Эрлэгийн эзэн бээр барьсан өмнийн үүдний зан үйл тонилох мөрийн гэгээн зул", 23b-24a., дансны дугаар 3551.

¹⁹ zab pa dang rgya che ba'i dam pa'i chos kyi thob yig gsal ba'i sgron me zhes bya ba bzhugs so

"Гүн хийгээд аугаа дээдийн номын товьёог тодорхой зул хэмээх оршив. 283b-284a., ja (жа) боть.

²⁰ dpal rdo rje 'jigs byed kyi sgrub thabs bsdus pa nyon mongs mun sel nam mkha'i nor bu zhes bya ba bzhugs.

"Цогт очир Жигжидийн бүтээлийн аргын хураангуй нисванисын харанхуйг арилгах огторгуйн чандмани", 7b., дансны дугаар 3538.

²¹ rje btsun ma ku ru ku we'i sgrub thabs dngos grub myur du 'gug pa'i lcags kyu zhes bya ba bzhugs.

"Тойн эх Гүрүгүвийн бүтээлийн арга шидийг түргэн дуудах төмөр гох", 6b., дансны дугаар 3534.

"Лус, балин, рашааны урсгал хэмээх оршив" хэмээх үүнийг сүсэг гайхамшиг болсон мэргэн цорж Гэндэнсамбуу бээр өчүүхэн дэлгэрэнгүй нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бичсэн²² гээд "Сайтар оршуулах сайн буяны далайн хур буухын тааллын утга маш тодорхой хоёр чуулганы сан хөмрөг хэмээх оршив... хэмээх үүнийг номд хурах их унзад Лувсанчүлтэм гарт авах нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд²³ "Ялж төгс нөгчсөн цагаан шүхэртийн үүднээс хариулан няцаах оршив..." хэмээх үүнийг сүсэг төгөлдөр Даян унзад Лувсанчүлтэм хариулан няцаахын эхлэл төгсгөлийн ёс амар хялбар нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд²⁴ тус тус бүтээсэн хэмээжээ. Зарим ном бүтээхийг олонтоо гуйж байсан учир "Жамьянгаравын бүтээлийн арга билэгийг гийгүүлэгч" үүнийг Майдарын бухар хийдийн гэсгүй бээр дахин дахин дуртгасанд²⁵, "Түргэнээ зохиох бэлгэ билгийн итгэл зургаан мутартаны тугдамыг хангах судрын зан үйл, барцад бүгдийг арилгах хэмээх оршив"... үүнийг номд оюуны нүдэн дэлгэрсэн мэргэн цорж энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дахин дахин дурдсанд бүтээсэн хэмээжээ.²⁶

Лувсанноровшарав өөрийн шавь нар, дотны найз нөхдийн хүсэл гуйлтыг бас анхаарч үзэн эдгээр бүх хүмүүст буян санаж зохиолоо бичсэн байна. Ном бүтээхийг гуйсан төрийн ихэс ноёдыг хүчний хүрд орчуулагч, олз учрал хотол төгссөн, хүчин чадал гайхамшигт болсон, Чингисийн удамд мэндэлсэн, эрхтэнийг амарлиулсан, сүсэг гайхамшиг болсон, дээдийн номд сүсэгт, бат хичээнгүй, буяны зүгт хичээнгүй чанарыг онцлон магтсан байна.

Хоёр. Хэрхэн бүтээсэн тухайд

Лувсанноровшарав Ү Далай лам Агваанлуvsанжамц, банчин богд Лувсанчойжижалцанбалсанбуу нарын төвд мэргэдийн зохиолыг голлон судалсан, тэдгээрийг үндэс болгож бусад зохиолуудаар баяжуулан өөрийн оюунаар тунгаан дэлгэрүүлж, хураангуйлж, заримыг тайлбарлаж, заримыг хялбарчилж бичсэн, ингэхдээ хүмүүсийн гуйлтыг үндэс болгосон байна. Тухайлбал "Их хөлгөний сожонгийн санваар авах зан үйл тонилохын амар мөр" хэмээх үүнийг хамгийг айлдагч Агваанлуvsанжамцбалсанбуу бээр зохиосон "Их хөлгөний сожонгийн санваарыг авсан зан үйлийг үндэс болгож судраас айлдсан тус эрдэм ба их богд Адишагийн "Ёсны шалтгаан үр долоон увьдасын ёс", банчин хамгийг айлдагч Лувсанчойжижалцанбалсанбуугийн зохиосон "Хоёр санваарын ялгал" хийгээд өөрийн оюунаар алимадыг хэмжсэн сайн

²² *klu gtor bdud rts'i'i chu rgyun zhes bya ba bzhugs.*

"Лус, балин, рашааны урсгал хэмээх оршив", 18b., дансны дугаар 3545.

²³ *rab gnas dge legs rgya mtsho'i char 'bebs kyi dgongs don rab gsal tshogs gnyis bang mdzod ces bya ba bzhugs so.*

"Сайтар орчуулах сайн буяны далайн хур буухын тааллын утга маш тодорхой хоёр чуулганы сан хөмрөг" хэмээх оршив, 51b-52a., дансны дугаар 3541.

²⁴ *bcom ldan 'das gdugs dkar mo can gyi sgo nas bzlog bsgyur byed tshul bzhugs*

"Ялж төгс нөгчсөн цагаагчин шүхэртийн үүднээс хариулан няцаах оршив", 8b., дансны дугаар 3544.

²⁵ *'jam dbyangs dkar po'i sgrub thabs shes rab gsal byed ces bya ba bzhugs.*

Жамьянгаравын бүтээлийн арга билигийг гийгүүлэгч", 4a., дансны дугаар 3533.

²⁶ *myur mdzad ye shes kyi mgon po phyag drug pa'i thugs dam bskang ba'i mdos kyi cho ga bar chad kun sei zhes bya ba bzhugs*

"Түргэнээ зохиох бэлгэ билгийн итгэл зургаан мутартны тугдамыг хангах судрын зан үйл, барцад бүгдийг арилгах хэмээх оршив", 21b., дансны дугаар 3546.

хувиар чимээд” бүтээсэн гэжээ.²⁷ Лувсанноровшарав ямар ямар зохиол ашиглаж тухайн зохиолоо бичсэнээ тодорхой дурдсан байна. Эндээс бид тухайн зохиолоо бичихдээ бусдын зохиолыг хэрхэн яаж боловсруулж баяжуулсан буюу ямар санааг уламжлан авч ямар санааг шинэчлэн баяжуулж чадсан, зохиогчийн өөрийн дэвшүүлсэн шинэ санаа, тухайлбал монголын нөхцөлд бурханы шашны үзэл санааг хэрхэн тааруулж тохируулсан зэргийг мэдэх боломжтой юм.

Гурав. Хаана бүтээсэн тухайд

Лувсанноровшарав ихэнхи зохиолоо Гэданшаддүвданпэлва хийдэд найруулав хэмээсэн байна. Харин цөөн зохиолоо Билэгийг арвижуулах сүм хэмээн алдаршсан хийдэд найруулав хэмээжээ. Зарим зохиолоо хаана бичсэнээ тодорхой дурдаагүй байна. Тухайлбал ордосын Ойдовжамцын хүсэлтээр бүтээсэн зохиолоо ямар газар бүтээснээ дурдаагүй байна. Ер нь ном бүтээлээ туурвиж байсан гол газар бол Гэданшаддүвданпэлва буюу Буян төгөлдөр номлол бүтээлийн төгс арвижих хийд байжээ.

Дөрөв. Хэзээ бүтээсэн нь

Норовшарав зохиолоо хэзээ бүтээсэнээ цөөн зохиолынхоо төгсгөлд дурдсан байна. Тухайлбал :

“Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур” хэмээх зохиолоо эрх баялаг хэмээх гал эм үхэр жилийн билгийн есөн сарын улаан зүгийн хоёрдугаар сайн бурхан багш тэнгэрээс буусан дүйчинд буюу 1757 онд²⁸, “Ялж төгс нөгчсөн Доржмэтүгбагийн зан үйл амьтан бүхний эвэршээлийн халуун энэлэлийг арилгах гаврын урсгал” зохиолоо тийн гарсан хэмээх эр шороо луу жилийн доо хэмээх монгол хоёрдугаар сарын цагаан зүгийн баясгалант хоёрдугаар өдөр буюу 1748 онд²⁹, “Ишгомбод сан тахил өргөх ёс хүссэн хэрэг бүхэн гарах хэмээх оршив” хэмээх зохиолоо эдийн үйлдэгч хэмээх эр гал барс жилийн доо сар төгссөн гуравдугаар өдрийн наран хувилах сайн цагт бичсэн буюу 1746 онд тус тус бүтээжээ.³⁰

²⁷ theg chen po'i gso sbyong gi sdom pa len pa'i cho ga thar pa'i bde lam zhes bya ba bzhugs.

“Их хөлгөний сожонгийн санваар авах зан үйл тонилохын амар мөр”, 7b-8a., дансны дугаар 3528.

²⁸ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi my u gu 'phei bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs.

“Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур”. 41b., дансны дугаар 3525.

²⁹ bcom ldan 'das rdo rje mi 'khrugs-pa'i cho ga 'gro-ba kun-gyi zug rngu'i tsha gdung sel-bar byed-pa'i ga bur gyi chu rgyun zhes bya ba zhug

“Ялж төгс нөгчсөн Доржмитүгбагийн зан үйл амьтан бүхний эвэршээлийн халуун энэлэлийг арилгах гаврын урсгал”. 33a., дансны дугаар 3550.

³⁰ ye shes-kyi mgon-po la bsangs mchod 'bul tshul dgos 'dod kun 'byung zhes bya ba bzhugs

“Ишгомбод сан тахил өргөх ёс хүссэн хэрэг бүхэн гарах хэмээх оршив”, 7a., дансны дугаар 3561.

Тав. Хэн бүтээсэн тухайд

Зохиогч өөрийн нэрийг шагжийн тойн Сумадиманипражня³¹, бурханы тойн Сумадиманипражня, сүсэг төгөлдөр³² "энэ ёсонд хичээнгүйлэгч шагжийн тойн Сумадиманипражня бээр машид тодорхой жигдэлсэн"³³ хэмээн олонтоо бичжээ. Сумадиманипражня бол Лувсанноровшаравын нэрийн санскрит орчуулга юм. Сумади бол Лувсан, мани нь норов, пражня бол шарав гэсэн үг болно. Лувсанноровшарав манжийн эзэн хаанаас түүнд Чин сүжигт номун хан хэмээх цол өгсөн тухайд "Мандшир дээдийн зарлигийн ачаар Чин сүжигт номун ханд дуудагдах" хэмээн бичжээ. Манай хуучны зохиолчдын нэгэн адил өөрийгөө дорд үзэн "адгийн тойн, дээд лам нарын зарлигийн боол, дээд лам нарын зарлигийн албат, дээд лам нарын зарлигийн ачаар чухал амьдрах тойн" гэхчилэн бичжээ. Төгсгөлийн үгэнд бас бичээч нарыг дурдсан байна. Түүний олонхи зохиолыг сайтар зарлигт, тийн шинжлэлд аугаа, тунгалаг билэгт Вагиндра Дармадала, сайтар шинжлэл туйлд болсон нягт билэгт Гунгааринчин нар бичсэн байна.

Зургаа. Зохиолын тус эрдэмийн тухай

Төгсгөлийн үгээ ерөөлөөр өндөрлөсөн байна. Үүнд зохиогч хамаг амьтан амар амгалан оршихыг ерөөхдөө тухайн зохиолыг бичсэн буянаар "Ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтны өвчин, ад, хилэнц, түйтгэр бүхэн ариусч бурханы хутгийг түргэнээ олох болтугай" гэх буюу "Ялгуусан шашин арван зүгт дэлгэрч арвижин хамаг амьтан орон үест цаг бусын үхэл тэргүүтэн зовлонгоос гэтлэн хязгаарт хүрэн туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай"³⁴ хэмээн бурханы шашин дэлгэрэн хөгжиж, улмаар хамаг амьтан аливаа өвчин зовлон нүгэл хилэнцээс ангижран сайн сайхны хамаг учрал төгсөхийн хамт бурхан болохыг ерөөсөн агуулгатай байна. Өөрөөр хэлбэл Лувсанноровшарав аливаа зохиолоо түмэн олны энх амгалан сайн сайханд зориулсан нь тодорхой харагдаж байна.

Ийнхүү Лувсанноровшаравын сүмбүмийн төгсгөлийн үгээс бид зохиогчийн намтар бүтээлд холбогдох баримт төдийгүй тухайн нийгэм цаг үе болон түүхт хүмүүсийн тухай олон сонин мэдээ баримтыг олж мэдэх боломжтой юм. Лувсанноровшаравын намтар бүтээлийг сонирхон судлах хүмүүст тустай болов уу хэмээн санаж төгсгөлийн үгийг төвд хэлнээс орчуулж хавсаргав.

³¹ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi my u gu 'phel bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs.

"Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур", 41a-41b., дансны дугаар 3525.

³² ye shes-kyi mgon-po la bsangs mchod 'bul tshul dgos 'dod kun 'byung zhes bya ba bzhugs

"Ишгомбод сан тахил өргөх ёс хүссэн хэрэг бүхэн гарах хэмээх оршив", 7a., дансны дугаар 3561.

³³ lha bzhi dril sgrub-kyi ting nge 'dzin gyi dbang rgyun-du blang-ba'i rim-pa bdud rtsi'i char 'bebs zhes bya ba bzhugs

"Бэгз, Жамсран сахиуст сан тахил өргөх ёсон санасан бүхэн бүтэг хэмээх оршив", 7a., дансны дугаар 3567.

³⁴ bzhan-po spyod-pa'i sgo-nas 'chi bslu jiltar bya tshul-gyi cho ga'i dag 'don dus min'chi'joms zhes bya ba zhugs/

"Сайныг эдлэх үүднээс үхлийг хуурахыг ямар мэт үйлдэх зан үйлийн уншлага, цаг бусын үхлийг дарах хэмээх оршив", ба., дансны дугаар 3548.

Лувсанноровшаравын сүмбүмийн төгсгөлийн үгийн орчуулга

КА боть

3525³⁵

"Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур" хэмээх үүнийг мянган бурханы хөргийг шинээр агуулсан ба аравнайлсан үед сэтгэл номхон ба чухал амарлингуйг үл хагаслах сүсэг төгөлдөр тойн Доржжалцан алдрын дуун бүхий мөргөл ерөөл нэгэн хэрэгтэй хэмээн дурдсан хийгээд би ч багш тэдгээрт дээд сүжгээр чухал дурдсаныг нөхцөл болгож мянган бурханы алдрыг "Сайн галавын" судраас зарлигласанчлан ерөөлүүд, "Алтангэрэл" судраас зарлигласанчлан мөргөл, тахилын үе гишүүн сэлтээр завсрыг барилдуулан дээд лам нарын зарлигийн ачаар чухал амьдрах шагжийн тойн Сумадиманипражня, бусад нэрээр Мандширийн зарлигийн ачаар Чин сүжигт номун ханд нэр дуудагдах бээр эрх баялаг хэмээх гал эм үхэр жилийн билгийн 9 сарын улаан зүгийн 2-р сайн бурхан багш тэнгэрээс буусан дүйчэнд дээд Мандширийн зарлигаар Билгийг арвижуулах сүм хэмээн алдаршсан хийдэд найруулав. Бичээч нь бигшү Вагиндра Дармадала болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан туулсан бурханы хутгийг түргэн олох болтугай.

3526³⁶

"Хутагт эх тонилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц түйтгэр бүгдийг машид угаах рашааны их хур" хэмээх үүнийг хүчний хүрдэн орчуулагч Чингис хааны удам угсаат хүчин хийгээд олз учралын хотол чуулган төгссөн ордосын Ойдовжамц энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дуртгасанд энэ зан үйл тарнийн ёс лугаа барилдлага их хэрэггүй байсан боловч дурдсан таалалд нийцүүлэн үйлийн дандар лугаа барилдуулваас гэмгүй бус уу хэмээн санаж бурханы тойн Сумадиманипражня зан үйлийн уншлагад "Нартанжаза"-гаас зарлигласанчлан "Чадагч найдан жүдүгийн бүтээлийн арга" мэт их хөлгөний Сожонгийн (дэгжээн арилгагч) уншлага өчүүхэн адил бус байх боловч банчин Лувсанчойжижалцангийн таалалчлан хийгээд судраас гарах зан үйл хийгээд тус эрдэмийг товч хураагаад өөрийн оюунаар алимад шинжилсэнээр сайн хувиар чимэж жигдлэсэний бичээч нь гүүш Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч өнөд орших ба хамаг амьтны хоёр түйтгэрийг судалж хоёр чуулганыг төгсгөөд илт туулсан бурханы хутгийг олох болтугай. Өлзий хутаг орших болтугай.

3527³⁷

"Лам хийгээд Мандширийг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох" хэмээх үүнийг ламд чин сүжиг төгөлдөр буяны

³⁵ bskal bzang sangs rgyas stong phrag gi phyag mchod smon lam dang bcas pa bsod nams kyi my u gu 'phel bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs.

"Сайн галавын мянган бурханы мөргөл, тахил, ерөөл лүгээ сэлт буяны ногоог арвижуулан үйлдэх рашааны их хур".

³⁶ 'phags pa thar pa chen po phyogs su rgyas pa'i mdo sde 'don pa'i cho ga sdig sgrib thams cad rab tu 'khru bar byed pa'i bdud rtsi'i char chen zhes bya ba ' bzhugs so.

"Хутагт эх тонилохуй зүгт дэлгэрсэн судрын аймгийг унших зан үйл хилэнц түйтгэр бүгдийг машид угаан үйлдэх рашааны их хур".

³⁷ bla ma dang 'jam dbyangs zung 'brel gyi bla ma'i rnal 'byor byin rlabs myur 'jug ces bya ba bzhugs.

"Лам хийгээд Мандширийг хослон барилдуулсан ламын йог адистидэд түргэн орох".

зүгт их хичээнгүй, сэтгэл номхон бөгөөд сайтар амарлиулсан Доржжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд шагжийн тойн Сумадиманипражня Гэданшаддүвданпэлва хийдэд найруулав. Бичээч нь сайтар шинжлэлийн туйлд хүрсэн гүүш Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан туулсан бурханы хутгийг түргэн олох болтугай.

3528³⁸

"Их хөлгөний сожонгийн санваар авах зан үйл тонилохын амар мөр" хэмээх үүнийг урьд хураасан сайн буяны хүчнээс илт өндөр болоод дээдийн номд сүсэгт, хичээнгүй, тийн шинжлэл дээд аугаа ордосын бэйл Ойдовжамц энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд шүтэж хамгийг айлдагч Агваанлуvsанжамцбалсанбуу бээр зохиосон "Их хөлгөний сожонгийн санваарыг авсан зан үйлийг" үндэс болгож судраас айлдсан тус эрдэм ба их богд Адишагийн "Ёсны шалтгаан үр долоон увдисын ёс" ба банчин хамгийг айлдагч Лувсанчойжигалцанбалсанбуугийн зохиосон "Хоёр санваарын ялгал" ба өөрийн оюунаар алимадыг хэмжсэн сайн хувиар чимээд шагжийн тойн Сумадиманипражня бээр найруулав. Бичээч нь тийн шинжлэл төгс Вагиндра Дармадала болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан ялгуусны хөвгүүний явдлын их давалгаар анхааран авч туулсан бурханы хутгийг түргэн олох болтугай.

3529³⁹

"Суртгаалыг огоот судалсан зан үйлийн санваарыг хичээн баясгагч" хэмээх үүнийг ном уруудах хийгээд эрхтэн чухал амаржсан гэлэн Лувсанжалцан хэмээх гарын авлага болох амар энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд Дулзин Дагважалцангийн зохиосон "Гурван шүтээний зан үйлээс" сожон ямар мэт үйлдэх ёсыг онцгойлон гаргасны үндсэн дээр "Гурван санваарын гадна заслыг ямар мэт үйлдэх ёсны зан үйлийг нэмж, тэнгэрийн тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь сэтгэл номхон хийгээд эрхтэнийг чухал амарлиулсан шинжлэл төгөлдөр гавж Чойжалцан болой. Үүгээр ялгуусны шашин их эрдэнэ дэлгэрэн арвижиж өнөд орших ба амьтан бүхэн хамгийг айлдагчийн билгийг олох болтугай."

3530⁴⁰

"Бацаг сахисаны тус эрдэм товч хураангуй сүсгийн ногоо" хэмээх үүнийг ариун хүний дүрст хүчний дүрсийг орчуулагч Чингис хааны овог язгуурт мэндэлсэн сүсэг хийгээд учрал хотол чуулсан ордосын бэйл Ойдовжамц бусдад туслахыг таалсан үлэмж санаагаар бүхнээс гуйж энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигласанд дээд лам нарын зарлигийн албат доод тэнгэрийн тойн Сумадиманипражня даруйд үйлдэв. Бичээч нь тийн шинжлэл төгс Вагиндра Дармадала болой. Үүгээр ч бурханы шашин зүг, цаг, орон үе бүхэнд дэлгэрч өнөд орших ба хамаг амьтан тийн ариун шагшаабадыг сахих тэргүүтэнд шүтэж туулсан бурханы хутгийг түргэн олох болтугай.

³⁸ theg chen po'i gso sbyong gi sdom pa len pa'i cho ga thar pa'i bde lam zhes bya ba bzhugs.

"Их хөлгөний сожонгийн санваар авах зан үйл тонилохын амар мөр".

³⁹ bslab pa yongs su sbyong ba'i cho ga sdom brtson dgyes byed ces bya ba bzhugs.

"Суртгаалыг огоот судалсан зан үйлийн санваарыг хичээн баясгагч".

⁴⁰ bsnyen gnas bsrungs pa'i phan yon mdor bsdus pa dad pa'i my u gu zhes bya ba bzhugs.

"Бацаг сахисаны тус эрдэм товч хураангуй сүсгийн ногоо".

3531⁴¹

"Лам хийгээд нууц хураангуй ялгал үгүй ламын йог сайн буяны хотол соёрхол" хэмээх үүнийг хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны язгуурт мэндэлсэн Сүнрав вангийн хөвгүүн ба хүчин төгөлдөр ноён Балдан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд тэнгэрийн тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь номд оюуны нүдэн дэлгэрсэн гэлэн Лувсанчойдон болой. Үүгээр ч хоёрдугаар ялгуусаны шашин эрдэнэ арвижин дэлгэрч өнөд орших болтугай.

3532⁴²

"Жанрайсиг бадамгарав"-ын бүтээлийн арга шидийн хүслийг саах" хэмээх үүнийг Барихази доторхи бүтээлийн аргыг үндэс болгож жүдээс номлосон тус эрдмийг нэмээд шагжийн гэлэн Сумадиманипражня бичив. Богд Мандширийн номын ах Доржжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд шүтэж бурханы тойн Сумадиманипражня найруулсан, бичээч нь Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин өнөд орших ба хамаг амьтан Мандширийн хутгийг олох болтугай.

3533⁴³

"Жамьянгаравын бүтээлийн арга билигийг гийгүүлэгч" үүнийг Майдарын бухар хийдийн гэсгүй дахин дахин дуртгасанд Нартанжазагаас зарлигласан бүтээлийн үндэс болгож дээд ламын мутарын таалалаар чимээд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Үүгээр ч ялгуусны шашин эрдэнэ зүг, цаг, орон ахуй үес бүхэнд дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

3534⁴⁴

"Тойн эх Гүрүгүвийн бүтээлийн арга шидийг түргэн дуудах төмөр гох" хэмээх үүнийг ариун хүний дүрст хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны язгуурт мэндэлсэн бөгөөд сүсэг хийгээд олз учрал хотол төгссөн Жамьяндоржван энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь тийн шинжлэл гайхамшиг болсон гүүш Лувсандовдон болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан дээд махамудрын шидийг олох болтугай.

3535⁴⁵

"Тойн дарь эхийн бүтээлийн арга" хэмээх үүнийг чухал хэрэглэгч бурханы тойн Сумадиманипражня найруулав. Үүгээр ч шашин дэлгэрч арвижих болтугай.

⁴¹ bla ma dang gsang ba 'dus pa dbyer med kyi bla ma'i rnal 'byor dge legs kun stsol zhes bya ba bzhugs.

"Лам хийгээд нууц хураангуй ялгал үгүй ламын йог сайн буяны хотол соёрхол".

⁴² rje btsun 'jam pa'i dbyangs kyi sgrub thabs bsdus pa ma rig mun sel zhes bya ba bzhugs.

"Жанрайсиг бадамгарван"-ы бүтээлийн арга шидийн хүслийг саах".

⁴³ 'jam dbyangs dkar po'i sgrub thabs shes rab gsal byed ces bya ba bzhugs.

"Жамьянгаравын бүтээлийн арга билигийг гийгүүлэгч".

⁴⁴ rje btsun ma ku ru ku we'i sgrub thabs dngos grub myur du 'gug pa'i lcags kyu zhes bya ba bzhugs.

"Тойн эх Гүрүгүвийн бүтээлийн арга шидийг түргэн дуудах төмөр гох".

⁴⁵ rje btsun sgrol ma'i sgrub thabs bzhugs so.

"Тойн дарь эхийн бүтээлийн арга".

3536⁴⁶

"Догшин чагдорын үйлийн чуулган" хэмээх үүнийг цорж Лувсанжалцан дурдсанд "Догшин их хилэнтийн дандар"-аас номлосончлон шагжийн гэлэн Сумадиманипражня бичсэн болой. Өлзий

3537⁴⁷

"Хөх хувцаст чагдорын бүтээлийн аргын хураангуй шид бүхэн гарах" хэмээх үүнийг сүсэг төгөлдөр бурханы тойн Лувсандаржаа тэргүүтэн дурдсанд тойн Агваанчойдог тэргүүтний зарлигийн үргэлжлэл мэт бурханы тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижих хийгээд хамаг амьтан шидийн сан хөмрөгт эрх учралт болох болтугай. Өлзий

3538⁴⁸

"Цогт очир Жигжидийн бүтээлийн аргын хураангуй нисваанисын харанхуйг арилгах огторгуйн чандмани" хэмээх үүнийг хүчний хүрдэн орчуулагч Чингис хааны удамд мэндэлсэн бөгөөд сайтар зарлигийн эрхтийн хөвгүүн Балдан хийгээд билэг хийгээд баатар хүчин сүсгийн хүчин төгөлдөр ноён Норовданзан ба утгыг чухалчлагч олон дурдсанд тэнгэрийн тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин ер хийгээд ялангуяа гурван орны номын хаан их Зонховын судар дандарын их эрдэнийн шашин дэлгэрч арвидан өнөд орших ба хамаг амьтан Мандширийн хутгийг түргэнээ олох болтугай.

3539⁴⁹

"Цогт очир Жигжидийн үүднээс зарлигийг захих ёсон" хэмээх үүнийг хүрдэн орчуулагч Чингис хааны үндсэнд мэндэлсэн бөгөөд сүсгийн хүчин төгс эрдэнэ ноён цорж Сандаг энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд чин сүжигт номун хаан буян төгөлдөр номлол, бүтээлийн шашин арвидах хийдэд үйлдэв, бичээч нь гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин арвидан дэлгэрээд өнөд орших ба хамаг амьтан Жанрайсигийн хутгийг түргэнээ олох болтугай. Өлзий.

3540⁵⁰

"Сайтар оршуулахын зан үйл сайн буяны хур буух хэмээх оршив" хэмээх үүнийг номд сэтгэл үлэх бат хичээнгүй эрхэм тойн гэлэн Лувсангомбо энэ мэт гарт авахуй хялбар хураангуй нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд тэнгэрийн тойн Сумадиманипражня мэргэний сайн номлолуудаас хураангуйлан найруулав, бичээч нь тийн шинжлэл төгөлдөр гавж Чойжалцан болой. Үүгээр ч ялгуусны шашин өнөд орших болтугай.

⁴⁶ phyag rdor gtum po'i las tshogs bzhugs.

"Догин чагдорын үйлийн чуулган".

⁴⁷ phyag rdor gos sngon can gyi sgrub thabs bsdus pa dngos grub kun 'byung zhes bya ba bzhugs

"Хөх хувцаст чагдорын бүтээлийн аргын хураангуй шид бүхэн гарах".

⁴⁸ dpal rdo rje 'jigs byed kyi sgrub thabs bsdus pa nyon mongs mun sel nam mkha'i nor bu zhes bya ba bzhugs.

"Цогт очир Жигжидийн бүтээлийн аргын хураангуй нисванисын харанхуйг арилгах огторгуйн чандмани".

⁴⁹ dpal rdo rje 'jigs byed kyi sgo nas bka'a bsgo bya tshul bzhugs.

"Цогт очир Жигжидийн үүднээс зарлигийг захих ёсон".

⁵⁰ gab gnas kyi cho ga dge legs char 'bebs zhes bya ba bzhugs so.

"Сайтар оршуулахын зан үйл сайн буяны хур буух" хэмээх оршив.

3541⁵¹

“Сайтар орчуулах сайн буяны далайн хур буухын тааллын утга маш тодорхой хоёр чуулганы сан хөмрөг хэмээх оршив” хэмээх үүнийг номд хурах их унзад Лувсанчүлтэм гарт авах нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд Банчэн эрдэний зохиосон “Сайтар оршуулах сайн буяны хур буух”-аар шүтээн үйлдээд хамгийг айлдагч Гэндэнжамцын зохиосон “Сайтар оршуулахын өлзийн хонгорцог” хийгээд их үндэс Гончогжалцанбалсанбуугийн зохиосон “Мутрын авалга” хийгээд Жанжаа Доржчангийн зохиосон “Сайтар оршуулах сайн буяны далайн сүрдэв” хийгээд судар дандраас тус эрдэм өчүүхнийг хураагаад тахилын боол хийгээд дээд лам нарын зарлигийг боол адагийн, бурханы тойн Сумадиманипражня бус нэрээр Мандшир дээдийн зарлигийн ачаар чин сүжигт номун хаанд дуудагдах, буян төгөлдөр Шаддүвданпэлва хийдэд найруулав. Бичээч нь сайтар зарлигт тийн шинжлэл аугаа тунгалаг билигт Вагиндра Дармадала болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвидан өнөд орших ба хамаг амьтан насан хамагтаа чухаг дээд гурав лугаа хагацалгүй туулсан бурханы хутгийг өнөд олох болтугай. Өлзий

3542⁵²

“Тэнгэрт авшиг өргөхийн зан үйл сайн буяны далайн хур буухын хөнгөн зүрх оршив” хэмээх үүнийг их дээд Мандширийн зарлигаар сайшаасан Чин сүжигт Номун хаан өөрт сонссон бага болоод тийн шинжлэл машид мөхөс боловч өөр лүгээ сацуутанд туслах сэтгэлээр хамгаас гуйж цог төгөлдөр доод жүд дацангийн “Мутрын авалга” найруулсан тэнгэрт авшиг өргөх зан үйлийг шүтээн болгож, шавьд авшиг өргөсөн зарим зан үйл хийгээд Дүлзинринбүчигийн зохиосон “Сайтар оршуулах дэлгэрсэний сэмбрий тэргүүтнээр тусгаар нэмж чимээд найруулав, бичээч нь судар дандар хоёр гол номд оюуны нүдэн дэлгэрсэн мэргэн цорж Сумадисагара болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан гурван биеийн хутгийг түргэнээ олох болтугай.

3543⁵³

“Цог төгөлдөр Марсарын хатны бүтээлийн аргыг хураасан уншлага” үүнийг сүсэг төгөлдөр гэлэн Ишзундуй энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дахин дахин дурдсанд хамгийг айлдагч Гэндэнжамц Балсанбуугийн зохиосон “Билгийн зан үйлд” шүтэж, бурханы тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин хамаг амьтны мөрийн барцад бүгдийг арилгаж, зохилдох нөхцөл бүгд сэтгэлчлэн бүтэх ба туулсан бурханы хутгийг олох болтугай.

⁵¹ rab gnas dge legs rgya mtsho'i char 'bebs kyi dgongs don rab gsal tshogs gnyis bang mdzod ces bya ba bzhugs so.

“Сайтар орчуулах сайн буяны далайн хур буухын тааллын утга маш тодорхой хоёр чуулганы сан хөмрөг” хэмээх оршив, 51b-52a.

⁵² lha la dbang bskur ba'i cho ga dge legs rgya mtsho'i char 'bebs kyi yang snying zhes bya ba bzhugs

“Тэнгэрт авшиг өргөхийн зан үйл сайн буяны далайн хур буухын хөнгөн зүрх оршив”.

⁵³ dpal ldan dmag zor gyi rgyal mo'i sgrub thabs bsduṣ pa'i ngag 'don bzhugs.

“Цог төгөлдөр Марсарын хатны бүтээлийн аргыг хураасан уншлага”.

3544⁵⁴

"Ялж төгс нөгчсөн цагаагчин шүхэртийн үүднээс хариулан няцаах оршив" хэмээх үүнийг сүсэг төгөлдөр Даян унзад Лувсанцүлтэм хариулан няцаахын эхлэл төгсгөлд ямар мэт үйлдэх ёс амар нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан өвчний адын хилэнц түйтгэр тэргүүтэн үл зохилдох зүг бүгдээс ялгуух болтугай.

3545⁵⁵

"Лус, балин, рашааны урсгал хэмээх оршив" хэмээх үүнийг сүсэг гайхамшиг болсон мэргэн цорж Гэндэнсамбуу өчүүхэн дэлгэрэнгүй нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд шүтэж хамгийг айлдагч Лувсанчойжжалцанбалсанбуугийн зохиосон "Лус балин рашааны гэлаша"-г шүтээнд тавин хамгийг айлдагч Агваанлуvsсанжамцын зохиосон "Лус балин рашааны эх урсгалаар" тусгайлан чимэж өөрийн аль хэмжсэн сайн хувиар чимээд шагжийн тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь тийн шинжлэл лугаа төгөлдөр гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин эрдэнэ дэлгэрч арвидан өнөд орших ба хамаг амьтны өвчин, ад, хилэнц, түйтгэр бүхэн арилан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3546⁵⁶

"Түргэнээ зохиох бэлгэ билгийн итгэл зургаан мутартны түгдамыг хангах судрын зан үйл, барцад бүгдийг арилгах хэмээх оршив" үүнийг номд оюуны нүдэн дэлгэрсэн мэргэн цорж энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дахин дахин дурдсанд мэргэний эрхтийн зохиосон судрын зан үйлийг шүтээнд үйлдэж дээд лам нарын зохиосон сайн хувиар чимээд бэлгэ билгийн итгэл зургаан мутартад үл ялгах сүсэг төгөлдөр бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь гүүш цорж Гунгааринчен болой.

КНА боть

3548⁵⁷

"Сайныг эдлэх үүднээс үхэл хуурахыг ямар мэт үйлдэх зан үйлийн уншлага, цаг бусын үхлийг дарах хэмээх оршив" ... Сайн явдал энэ ч "Судрын аймаг олонхиос" гарсан тул судрын ёс лугаа барилдсан зонхи хэмээвч дээд зарим үйлсийн дандар лугаа адил нэгийг зохиосон буй тул түүн лүгээ зохилдуулан гарт авахуй хялбарыг бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь тийн шинжлэл аугаа равжамба Сумадивагиндра болой. Үүгээр ч ялгуусны шашин арван зүгт дэлгэрч

⁵⁴ bcom ldan 'das gdugs dkar mo can gyi sgo nas bzlog bsgyur byed tshul bzhugs

"Ялж төгс нөгчсөн цагаагчин шүхэртийн үүднээс хариулан няцаах оршив".

⁵⁵ klu gtor bdud rtsi'i chu rgyun zhes bya ba bzhugs.

"Лус, балин, рашааны урсгал хэмээх оршив".

⁵⁶ myur mdzad ye shes kyi mgon po phyag drug pa'i thugs dam bskang ba'i mdos kyi cho ga bar chad kun sei zhes bya ba bzhugs

"Түргэнээ зохиох бэлгэ билгийн итгэл зургаан мутартны түгдамыг хангах сударын зан үйл, барцад бүгдийг арилгах хэмээх оршив", 21b.

⁵⁷ bzan-po spyod-pa'i sgo-nas 'chi bslu jiltar bya tshul-gyi cho ga'i dag 'don dus min'chi 'joms zhes bya ba zhugs/

"Сайныг эдлэх үүднээс үхлийг хуурахыг ямар мэт үйлдэх зан үйлийн уншлага, цаг бусын үхлийг дарах хэмээх оршив".

арвижин хамаг амьтан орон үест цаг бусын үхэл тэргүүтэн зовлонгоос гэтэлгэн хязгаарт хүрэн туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3549⁵⁸

"Ялж төгс нөгчсөн Цэвэгмэдэд шүтэж насны үрэл бүтээх зан үйл насан ба буян арвитгах санааг арвижуулах чандмани эрдэнэ хэмээх оршив" хэмээн бат оршуулан үйлд, цэцэг цац, ажрахыг хураан үйлд, өлзий өгүүлэн цэцгийн хур буулгах хэрэгтэй болой хэмээн ялж төгс нөгчсөнд шүтэж насны үрэл бүтээх зан үйл насан ба буян арвитгах сампэлидшинноров хэмээх үүнийг лам хийгээд чухаг дээд гурвыг үл ялгах сүсэг төгөлдөр өөрийн номын ах Доржжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь тийн шинжлэл төгс гүүш цорж Гунгааринчин болой. Үүгээр ч ялгуусны шашин арвижин дэлгэрч өнөд орших ба хамаг амьтан орон үест диваажинд төрөх ба Цэвэгмэдийн хутгийг түргэнээ олох болтугай. Сайн буян арвижигтун.

3550⁵⁹

"Ялж төгс нөгчсөн Доржмитүгвын зан үйл амьтан бүхний эвэршээлийн халуун энэлэлийг арилгах гаврын урсгал" хэмээх оршив. Бурхан Нан-ва-та-яй улбар шар бүжгээр тийн цэнгэх болсон ба банчин хамгийг айлдагч Лувсанчойжигалцанбалсанбуугийн зохиосон "Митүгвий бүтээлийн хот мандал огоот төгссөн зан үйлийг" шүтээнд агуулаад гартаа цагаан лянхуа барьсан улбар шар бүжгээр тийн цэнгэх ялгуусан эрхт хамгийг айлдагч Агваанлуvsанжамцбалсанбуугийн зохиосон Митүгба Лхагүмай хот мандлын зан үйл хийгээд Павонхаба Балжорлхүндэвийн явдлын үндсийн ёсонд зохиосон митүгба Лхагүгийн хот мандлын чога хийгээд Доржжанчэнбогийн мөрийн зэрэгт зарлигласнуудыг алимад орохуй хялбар ба үйлийн үндсийн өөрийн мөр ямар мэтчилэн бурханы тойн Сумадиманипражня тийн гарсан хэмээх эр шороон луу жилийн доо хэмээх монгол 2-р сарын цагаан зүгийн баясгалант 2-р өдөр буян төгөлдөр Шаддүвдампэл хийдэд найруулав. Бичээч нь нягт билигт Гунгааринчин болой. Үүгээр ч ялгуусны шашин эрдэнэ зүг, цаг, орон, үес бүхэнд дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтны зовлон ба хилэнц түйтгэр бүхэн арилж туулсан бурханы хутгийг олох болтугай.

3551⁶⁰

"Эрлэгийн эзний барьсан өмнийн үүдний зан үйл тонилох мөрийн гэгээн зул хэмээх оршив" хэмээх энэ нь мэргэн, тойн, сайн, гурвын эрдэм лугаа төгөлдөр билиг арвижуулах сүмийн Даа лам бандид цорж Лувсанжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсан ба өөрийн номын ах Доржижалцан бээр амарлингуй номын чанарт болсон цагт дөчин есөн хоногт түүний тусад өмнөд үүд дөчин есийг үйлдэх үест бурханы тойн Сумадиманипражня бээр дээдсүүдийн сайн номлолуудаас хурааж найруулав. Бичээч нь Лувсан-Одсэр болой. Үүгээр ч ялгуусны

⁵⁸ bcom ldan 'das tshe dpag med-la brten-nas tshe ril sgrub tshul-gyi cho ga tshe dang bsod nams 'phel-bar byed-pa'i bsam 'phel yid bzhin nor-bu zhes bya-ba bzhugs

"Ялж төгс нөгчсөн Цэвэгмэдэд шүтэж насны үрэл бүтээх зан үйл насан ба буян арвитгах санааг арвижуулах чандмани эрдэнэ" хэмээх оршив.

⁵⁹ bcom ldan 'das rdo rje mi 'khrugs-pa'i cho ga 'gro-ba kun-gyi zug mngu'i tsha gdung sel-bar byed-pa'i ga bur gyi chu rgyun zhes bya ba zhug

"Ялж төгс нөгчсөн Доржмитүгбагийн зан үйл амьтан бүхний эвэршээлийн халуун энэлэлийг арилгах гаврын урсгал".

⁶⁰ gshig-po rjes 'dzin lho sgo'i cho ga thar lam gsal-ba'i sgron me zhes bya-ba bzhugs/

"Эрлэгийн эзэн бээр барьсан өмнийн үүдний зан үйл тонилох мөрийн гэгээн зул".

шашин дэлгэрч арвидан өнөд орших ба хамаг амьтны хилэнц, түйтгэр ариусч түргэнээ илт туулсан бурханы хутгийг олох болтугай.

3552⁶¹

“Ерөөл дэлгэр үйлдэх ёсны тонилох мөрийн үүдийг нээхүй” хэмээх оршив ... хэмээх үүнийг дээдийн номд их утга чухалчлагч эрдэнэ цорж Лувсанжалцан хэмээх энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд дээд лам нарын зарлигийн албат доод адаг бурханы адаг бурханы тойн Сумадиманипражня үйлдэв. Бичээч нь тийн шинжлэл төгөлдөр Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвидан өнөд орших ба шашин барих дээд төрөлхтнүүдийн өлмийн лянхуаг батжуулан зохиох үйлс дэлгэрч, хамаг амьтан хотлыг айлдагч ялгуусны хутгийг түргэнээ олох болтугай. Буян болой, сайтар болой.

3553⁶²

“Ерөөл дунд үйлдэх ёсны дээд мөрийн үүдийг нээх хэмээх оршив”. Амьтны зовлонгийн гагц эм хэмээх тэргүүтэн ерөөлийн шүлгийн үе зохилдуулсан болой хэмээн “Ерөөл дундыг ямар мэт үйлдэх ёсны дээд мөрийн үүдийг нээхүй” хэмээх үүнийг номд утга чухалчлах заримын дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь тийн шинжлэл төгс Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин зүг, цаг, орон, үе бүхэнд дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

3554⁶³

“Ерөөлийн хураангуй ямар мэт үйлдэх ёсны тус амгалангийн үүдийг нээхүй хэмээх оршив” хэмээх үүнийг дээдийн номд их чухал утга төгөлдөр эрдэнэ цорж Лувсанжалцан хэмээх энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бурханы тойн Сумадиманипражня үйлдэв. Бичээч нь тийн шинжлэл төгөлдөр Гунгааринчен болой. Буян болой. Сайн болой.

3555⁶⁴

“Цогт очирьг сайтар дарах зан үйл тус амгалангийн дээд соёрхол сампэлноров хэмээх оршив” хэмээх үүнийг тийн шинжлэл төгөлдөр эрдэнэ цорж Лувсанжалцангийн дурдсанд дүвчэнмидрагийн зарлигийн үргэлжлэл хийгээд очир баригч Жамьянралдийгийн зохиосон хот мандлын зан үйлийг шүтээнд бариад шалгадаг төгөлдөр дээдийн журмын нэмэлт зохиосноор бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь оюуны нүдэн дэлгэр тунгалаг билигт Агваанчойпэл болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч өнөд орших ба хамаг Очирдарын хутгийг түргэнээ олох болтугай.

3556⁶⁵

“Доржпагма жүсүммагийн бүтээлийн арга их амгалангийн балгадад орох увьдис хэмээх оршив” хэмээх өчүүхэн шимийг авахын

⁶¹ bsdo-ba rgyas-pa bya tshul thar lam sgo 'byed ces bya-ba bzhugs so/

“Ерөөл дэлгэр үйлдэх ёсны тонилох мөрийн үүдийг нээхүй” хэмээн оршив.

⁶² bsdo-ba 'bring-po bya tshul lam mchog sgo sbyed ces bya-ba bzhugs-so/

“Ерөөл дунд үйлдэх ёсны дээд мөрийн үүдийг нээхүй хэмээх оршив”.

⁶³ bsdo-ba bsdus-pa ji ltar bya tshul phan bde'i sgo 'byed ces bya ba bzhugs-so/

“Ерөөлийн хураангуй ямар мэт үйлдэх ёсны тус амгалангийн үүдийг нээхүй”.

⁶⁴ dpal rdo rje rnam-par 'joms-pa'i cho ga phan bde'i mchog stsol bsam 'phel nor bu zhes bya ba bzhugs

“Цогт очирьг сайтар дарах зан үйл тус амгалангийн дээд соёрхол сампэлноров хэмээх оршив”.

⁶⁵ dro rje phag mo lha bcu gsum ma'i sgrub thabs bde-ba chen-po'i grong khyer-du 'jug-pa'i man ngag ces bya-ba bzhugs-so/

“Доржпагма жүсүм-ма-гийн бүтээлийн арга их амгалангийн балгадад орох увьдис хэмээх оршив”.

увдис рашааны шим хэмээх үүнийг Чингис хааны язгуурт мэндэлсэн сүсэг хийгээд тавих чимгээр үзэсгэлэнт ноён Ринченжамц энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд үйлээс хагацсан Зундуйнямбуу зохиосон "Өчүүхэн шим авахын увдисыг" шүтээнд үйлдээд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь тийн шинжлэл төгөлдөр гавж Чойжал нэрт болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин хамаг амьтны гурван биеийн хутгийг түргэн олох болтугай. Өлзий

3557⁶⁶

"Дөрвөн зуугийн зан үйл шуламсын үйлийг сайтар ялгуусан" хэмээх үүнийг ариун хүний дүрст хүчний хүрд орчуулагч Чингис ялгуусны үндсэнд мэндэлсэн ба хүчин гайхамшигт болсон ордосын бэйл Ойдовжамц энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд шүтэж богд Гэндэнжамцын зохиосон "Дөрвөн зуугийн зан үйлийг" шүтээнд тавиад банчин хамгийг айлдагч Лувсанчойжжалцангийн зохиосон "Жаший чога"-аар тусгайлан чимж урд үеийнхний олон гарын авлага заримыг нэмэн шагжийн тойн Сумадиманипражня үйлдэв. Бичээч нь тийн шинжлэл гайхамшиг болсон равжамба Сумадивагиндра болой. Үүгээр ч бурханы шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан дөрвөн шуламсыг сайтар ялж тийн удирдах туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3558⁶⁷

"Дарь эх тулалдааныг няцаах ямар мэт үйлдэх зан үйл, дайсны үйлийг сайтар ялгуусан лхантав оршив"...хэмээх үүнийг сэтгэлийг номхотгон эрхтэнийг чухал амарлиулсан аграмба Содномданзан бээр дурдсанд банчин хамгийг айлдагч их Лувсанчойжжжалцанбалсанбуу бээр зохиолыг ямар мэтчилэн үйлдсэнд сайтар хувь зарим нэг йагча олноос нэмэн бурханы тойн Сумадиманипражня бээр найруулав. Бичээч нь гүүш Сангабадра болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин орших ба амьтнуудын хоёр чуулганыг хураах харшлах нөхцөл, барцад амарлин, хамгийг айлдагч ялгуусны хутгийг амар хялбар олох болтугай. Мангалам

3559⁶⁸

"Доржхандын жинсрэг хилэнц уналын харанхуйг арилгах хэмээх оршив" хэмээх үүнийг өөрийн шавь судар дандарт тийн шинжлэл аугаа аграмба Содномданзан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд гурван орны номын хаан их Зонховын увдисыг шүтээнд үйлдэж бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь үл ялгах сүсэг төгөлдөр гүүш Сагадар болой. Үүгээр ч ялгуусны шашин эрдэнэ дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан хоёр түйтгэрийг ариусган туулсан бурханы хутгийг олох болтугай.

3560⁶⁹

"Эрлэгийг даган барих ёс тонилохын үүдийг нээхүй хэмээх оршив" үүнийг хүчний хүрд орчуулагч Чингис хааны удамд мэндэлсэн сонсох, санах, бясалгах гуравт хичээнгүй ба цог учрал, хотол чуулган төгс эрдэнэ

⁶⁶ brgya bzhi'i cho ga 'dud-las nam rgyal zhes bya-ba bzhugs/

"Дөрвөн зуугийн зан үйл шуламсын үйлийг сайтар ялгуусан".

⁶⁷ sgröl-ma gyul bzlog ji ltar bya-ba'i cho ga dgra las nam rgyal-gyi lhan thabs bzhugs-so/ "

Дарь эх тулалдааныг няцаах ямар мэт үйлдэх зан үйл, дайсны үйлийг сайтар ялгуусан лхантав оршив".

⁶⁸ rdo rje mkha' 'gro'i sbyin sreg sdig ltung mun sel zhes bya ba bzhugs-so/

"Доржхандын жинсрэг хилэнц уналын харанхуйг арилгах хэмээх оршив".

⁶⁹ gshig-po rjes su 'dzing tshul thar-pa'i sgo 'byed ces bya-ba bzhugs

"Эрлэгийг даган барих ёс тонилохын үүдийг нээхүй хэмээх оршив".

ноён цорж Самдан ба сүсэг төөлдөр лам эрдэнэ цорж Лувсанжалцан энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд дээд ламын зарлиг мэтчилэн бурханы тойн Сумадиманипражня бус нэрээр Чин сүжигт номун хан буян төгөлдөр Шаддүвданлэлвий хийдэд найруулав. Бичээч нь гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3561⁷⁰

"Ишгомбод сан тахил өргөх ёс хүссэн хэрэг бүхэн гарах хэмээх оршив" үүнийг хүчний хүрд орчуулагч Чингис хааны удамд мэндэлсэн бөгөөд бурханы шашинд сүсэг гайхамшиг болсон ноён Галсан хэмээх энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд шүтэж дээд ламын зарлигийг албат адаг доод 6 мухарт Ишгомбод үл ялгах сүсэг төгөлдөр тэнгэрийн тойн Сумадиманипражня идээн үйлдэгч эр гал барс жилийн доо сар төгссөн 3-р өдрийн наран ойр хувилах сайн цагт даруй үйлдсэн болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин хамаг амьтны газар мөрийн хамаг эрдэмийн хязгаарт туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3562⁷¹

"Их ялгуусан намтосрайд сан, тахил өргөх ёс, есөн хүслийн хур буух хэмээх оршив" үүнийг хүчин төгөлдөр ноён Галсандорж эрх дайчин дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3563⁷²

"Цог төгөлдөр Магсарын хатанд сан тахил өргөх ёс санаа арвитгах чандмани эрдэнэ хэмээх оршив" үүнийг хүчний хүрд орчуулагч Чингис хааны урагт мэндэлсэн сүсэг ба цог учрал хотол төгссөн Жамьяндорж вангийн хүү сүсэг хүчин төгөлдөр Цэрэндорж энэ мэт хураангуй нэгэн хэрэгтэй хэмээн дурсанд шагжийн тойн Сумадиманипражня бичив. Бичээч нь тийн шинжлэл аугаа гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин өнөд арвидан өнөд орших ба амьтан бүгдийн бодийг бүтээх барцадыг амарлиулан туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай.

3564⁷³

"Сан тахилын эрдэнийн сангийн хумх" хэмээх үүнийг ариун хүний дүрст хүчний хүрд орчуулагч Чингис хааны үндсэнд мэндэлсэн Далай цоохор бэйл энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд шүтэж бурханы тойн Сумадиманипражня найруулав. Бичээч нь Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин хамаг амьтан бурханы хутгийг олох болтугай.

⁷⁰ ye shes-kyi mgon-po la bsangs mchod 'bul tshul dgos 'dod kun 'byung zhes bya ba bzhugs

"Ишгомбод сан тахил өргөх ёс хүссэн хэрэг бүхэн гарах хэмээх оршив".

⁷¹ rgyal-po chen-po nam thos sras-la bsang mchod 'bul tshul 'dod dgu'i char 'bebs zhes bya ba bzhugs

"Их ялгуусан намтосрайд сан, тахил өргөх ёс есөн хүслийн хур буух хэмээх оршив".

⁷² dpai ldan dmag zor rgyal mo la bsang 'bul tshul bsam 'phei yid bzhin nor bu zhes bya ba bzhugs

"Цог төгөлдөр Магсарын хатанд сан тахил өргөх ёс санаа арвитгах чандмани эрдэнэ хэмээх оршив".

⁷³ bsang mchod rin chen gter bu ma zhes bya ba bzhugs

"Сан тахилын эрдэнийг сангийн хумх" хэмээх оршив.

3565⁷⁴

"Бангон чагжава тэргүүтнийг шинэхэн бүтээсний баржан оршив" хэмээх үүнийг ордосын даа бэйсийн далавчинд багтсан гэнэн Лувсандампэл номын өглөг аугаа ихэд арвидах тул Банганчагжаба хийгээд хутагт түүнчлэн ажирсны даяанаар хүчин үүсгэсэн биндэръяагийн гэрэл хэмээх тогтоол хийгээд тойн Зонховын зохиосон Диваажингийн ерөөлүүдийг шинээр бүтээсэн баржанд энэ мэт нэгэн хэмээн дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь Гунгааринчен болой.

3566⁷⁵

"Бэгз, Жамсран сахиуст сан тахил өргөх ёсон санасан бүхэн бүтэх хэмээх оршив" үүнийг ариун хүний дүрст хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны язгуурт сүсэг ба хүчин ба учрал хотол төгссөн далай Чойнхор бэйл Намжилцэсрүн энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд бурханы тойн Сумадиманипражня даруй үйлдэв. Бичээч нь тийн шинжлэл төгс тунгалаг билигт Вагиндрадармадала болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтны хоёр түйтгэр арилж хоёр чуулган төгсч түргэнээ илт туулсан бурханы хутгийг олох болтугай.

3567⁷⁶

"Лхашдилдүвийн даяаны эрхийг үргэлжид авахын дараалал рашааны хур буух хэмээх оршив" хэмээх үүнийг өөрийн номын ах Доржижалцан гарт авах хялбар нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд энэ ёсонд хичээнгүйлэгч шагжийн тойн Сумадиманипражня машид тодорхой жигдлэв. Бичээч нь тийн шинжлэл төгөлдөр гэлэн Сангабадра болой. Үүнд номлох үлэмж гэм юун бүхий бүгдийг лам ба итгэл хандмаа нар хүлцэн зохион соёрх. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан ялгуусан очирдарын хутгийг түргэнээ олох болтугай.

3568⁷⁷

"Зургаан мутарт Ишгомбод тахил балин өргөх дарааллыг товч хураангуйлсан барцад бүгдийг арилгах оршив" хэмээх үүнийг сүсэг төгөлдөр өөрийн ах Доржижалцан ба хүчний учрал төгссөн Дашравдан тэргүүтэн энэ мэт хураангуй нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бурханы тойн Сумадиманипражня найруулав, бичээч нь гүүш Лувсанчойдан болой. Үүгээр ч ялгуусны шашин дэлгэрч арвижин өнөд орших ба эх болсон хамаг амьтан туулсан бурханы хутгийг түргэн олох болтугай.

3569⁷⁸

"Дамбачойжилын гадаад, дотоод, нууц гурвын балин өргөх оршив" хэмээх энэ нь зүүдэнд дохио үзүүлсэн мэт эрлэгийн егзөр

⁷⁴ dpang skong phyag brgya-pa sogs gsar-du bsgrubs-pa'i sbar byang bzhugs/

"Бангон чагжава тэргүүтнийг шинэхэн бүтээсний баржан оршив".

⁷⁵ chos skyong beg tse lcam sring-la bsangs mchod 'bul tshul bsams-pa kun 'grub ces bya ba bzhugs

"Лхашдилдүвийн даяаны эрхийг үргэлжид авахын дараалал рашааны хур буух хэмээх оршив".

⁷⁶ lha bzhi dril sgrub-kyi ting nge 'dzin gyi dbang rgyun-du blang-ba'i rim-pa bdud rtsi'i char 'bebs zhes bya ba bzhugs

"Бэгз, Жамсран сахиуст сан тахил өргөх ёсон санасан бүхэн бүтэх хэмээх оршив".

⁷⁷ ye shes-kyi mgon-po phyag drug-pa la mchod gtor 'byl-ba'i rim-pa mdor bsdus-pa bar chad kun sel zhes bya-ba bzhugs

⁷⁸ dam can chos rgyal phyi nang gsang gsum-gyi gtor 'bul bzhugs/

бурханы тойн Сумадиманипражня гараар бичив. Үүгээр ч ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

3570⁷⁹

"Дамжан Чойжижалбогийн гадаад бүтээлд шүтсэн хадуурын зан үйл үзүүлэх дайсныг үнсэнд талхлах очирт аянга хэмээх оршив" хэмээх үүнийг санваар хичээнгүй дээд эрдэнэ цорж Одсэржалцан дурдсанд Банчин хамгийн айлдагч Лувсанчойжижалцангийн зохиосон "Нийт бусын жарыг ямар мэт үйлдэх зан үйлийг жигдэлсэн дээд дүр, амины тонгоргийг шүтээнд үйлдэн дээд лам нарын шалшман-агаар чимэн, мэргэдийн гарын авлага үзэх үндэс мэт бурханы тойн Сумадипражня найруулав, бичээч нь Дамбадарлингийн мэргэн цорж Сангабадра болой. Үүгээр ч ялгуусан шашин эрдэнэ харын зүгийн тулалдаанаас сайтар ялгуусан бөгөөд зүг бүхнээ дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

3571⁸⁰

Их ялгуусан алжаалыг тэжээгч Вишнүд тахил, балин өргөх үе зэрэг санааг арвитгах эрхтийн хаан хэмээх үүнийг Чингис хааны язгуурт мэндэлсэн бөгөөд сүсэг ба өглөг хотол төгссөн чимгээр чухал үзэсгэлэнтэй ноён Дамдин энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн ихэд шамдан дурдсанд шүтэж бурханы тойн Сумадипражня найруулав, бичээч нь тийн шинжлэл төгөлдөр гавж Чойжал нэрт болой. Үүгээр ч ялгуусан шашин эрдэнэ дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан үгээгүү доордсын зовлонгоос гэтэлж ном ба цог учрал хотол төгсөх болтугай.

3572⁸¹

"Их ялгуусан намтойсрайгийн балин өргөх үе зэрэг эрдэнийн хур буух хэмээх оршив" хэмээх үүнийг тийн шинжлэл төгөлдөр эрхэм дархан тойн Лувсаншарав ба эрдэнэ цорж Лувсанжалцан хоёр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд бурханы тойн Сумадипражня найруулав. Үүгээр ч ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

3573⁸²

"Хутагт цагаан замбал луу унасан эхийн бүтээлийн арга шидийн хур буух хэмээх оршив" үүнийг сүсэг ба учрал хотол төгс ноён Дашравдан гарт авахад хялбар нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд Шагжийн тойн Сумадипражня үйлдэв, бичээч нь номд оюуны нүдэн дэлгэрсэн нягт билигт Гунгааринчен болой. Үүгээр ч ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтны нисваанис хийгээд үгээгүү ядуугийн зовлонг амарлиулж туулсан бурханы хутгийг түргэнээ олох болтугай. Өлзий орших болтугай.

3574⁸³

"Сангийн хумх нуух ёсон, сүсэгт энэрэх байгуулах ёсны гарын авлага есөн хүслийн цог учрал гарах их сан хэмээх оршив" хэмээх энэ нь сэтгэл номхон бөгөөд эрхтэнийг чухал амарлиулсан номд оюуны нүдэн дэлгэрсэн гүүш цорж Лувсаннамжал ба тийн шинжлэл төгөлдөр эрдэнэ

⁷⁹ dam can chos-kyi rgyal-po phyi sgrub-la brten-pa'i zor-gyi cho ga bstan dgra thal-bar rlog-ba'i rdo rje'i gnam lcags zhes bya ba zhugs

⁸⁰ rgyal-po chen-po dal-bsos-po la mchod gtor 'bul ba'i rin-pa bsam 'phel dbang-gi rgyal zhes bya ba bzhugs

⁸¹ rgyal-po chen-po rnam thos sras-kyi bzhag gtor 'bul-ba'i rin-pa rin chen char 'bebs zhes bya ba bzhugs-so

⁸² 'phags-pa dzamabahal dkar-po 'brug zhon ma'i sgrub thabs dngos grub char 'bebs zhes bya ba bzhugs-so

⁸³ gter bum sba tshul dad-la brtse brtsig tshul-gyi lag len 'dod dgu'i dpal 'byor 'byung-ba'i gter chen zhes bya ba bzhugs

цорж Лувсанжалцан ямагт бусдын тусад гарт авахуй хялбар энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээх зарлигаар дурдсанд шүтэж, Годзий прүлжинжалба ба ловон Бадамжүнайн зохиосон "La brtse ba rtsig" ба газарч Миүтүнгийн зохиосон "газрын зан үйл" ба

3575⁸⁴

"Дөрвөн гарлагын балин тавих ёс оршив" хэмээх зан үйлийн уншлага олонхийг банчин эрдэнийн зарлиг ямар мэтчилэнд дээд лам нарын сайн хувиар чимээд их Мандшир дээдийн зарлиг эшээр Чин сүжигт номун ханд дуудагдах бус нэрээр тэнгэрийн тойн Сумадипражня найруулав, бичээч нь бигшү Вагиндра Дармадала болой.

3576⁸⁵

"Тэнгэрийн эрхт хурмастад тахил өргөх ёс" хэмээх үүнийг ариун хүний дүрст хүчний хүрдэн орчуулагч Чингис хаан ялгуусаны удамд мэндэлсэн бөгөөд чухаг дээд гурван мөрийг ялгах сүсэг төгөлдөр тэргүүтний сайшаасан, эрдмээр илт өндөр, хоёр ёсыг айлдагч мэлмий төгөлдөр хүчин учрал хотол төгссөн хүний эрхт 2-р жанжин хошой чин ван Чогонжав энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигаар дурдсанд шүтэж тэнгэрийн тойн Сумадипражня, бус нэрээр Мандшир дээдийн зарлиг эшээр Чин сүжигт номон ханд дуудагдах Гэданшаддүвпэлвий хийдэд найруулав, бичээч нь гүүш цорж Гунгааринчен болой. Үүгээр ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших болтугай.

GA боть

3480⁸⁶

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос анхдугаар боть болой"

NGA боть

3481⁸⁷

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос хоёрдугаар боть болой"

CA боть

3582⁸⁸

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос гуравдугаар боть болой"

⁸⁴ 'byung bzhi'i gtor-ma gtong tshul bzhugs-so.

⁸⁵ lha'i dang-po brgya byin-la bsangs mchod 'bul tshul dgos 'dod 'byung-ba'i yid bzhin nor-ba zhes bya ba bzhugs-so

⁸⁶ yi dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas thabs gsal-ba'i me long las glegs-ba ma dang-po bzhugs

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос анхдугаар боть болой".

⁸⁷ yi-dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas-kyi lhan thabs gsal-ba'i me-long glegs bam gnyis-pa bzhugs/

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос хоёрдугаар боть болой".

⁸⁸ yi-dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas-kyi lhan thabs gsal-ba'i me-long las glegs bam gsum-pa bzhugs/

"Ядамжамцын дүвтав эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос гуравдугаар боть болой".

СНА боть

3583⁸⁹

"Ядамжамцын дүгтэв эрдэнэ гарах орны лхантав тодорхой толиос дөрөвдүгээр боть болой"

...хэмээсэн энэ нь ариун хүний дүрст хүчний хүрдийг орчуулагч Чингис хааны үндэст ба хүчин хотол төгссөн далай ван Дашпэлийн хөвгүүн ноён хутагт бээр бүтээлийг арга эрдэнэ гарахын орны тэнгэр 301-ийн даган соёрхол огоот төгссөнийг олсон үед бүтээлийн арга үүнд би-г үүсгэх үед тэнгэр олонд төрсөн ч даган соёрхолын үед шавь нэгэн тэнгэрт төрсөн тэргүүтэн машид үл тодорхой бөгөөд ...амгалан бус олон байх тэргүүтнийг тодорхой дэлгэрүүлэн ухахад амар энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд их Мандширийн зарлиг эшээр Чин сүжигт номун ханд дуудагдах бус нэрээр тэнгэрийн тойн Сумадиманипражня бээр бүтээлийн арга эрдэнэ гарах түүнд адислав. Ригдан, жэй-нан, гомлүн, дайлүн тэргүүтний дон-ча ба гарын авалгын үе зоригийн хойд хойдхи нь урьд урьдахад шал-пан зохиоснууд алин буусны дэргэд тус тус тодорхой талбин бас ч тэнгэр өөр өөрийн үндэс ба бүтээлийн арга тэргүүтнээс аль хэрэгтэй нугуудыг хураагаад найруулсан болой. Үүгээр ч ялгуусан шашин дэлгэрч арвижин өнөд орших ба хамаг амьтан ялгуусан очирдарын хутгийг олох болтугай.

Ja боть

"Гүн хийгээд аугаа дээдийн номын товьёг тодорхой зул хэмээх оршив. Өлзий хутаг орших болтугай"... хэмээх оюуныг шударга оршуулагч зарим хийгээд өөрөөс оюун доор нугудад тус ч болох магад хэмээн санаж эрхэнд шавь нугудад тус магадыг үлэмж санан тийн ариунаар үндсийг дурдсан хийгээд билгийг арвитгах сүмийн даа лам бандид цорж Вагиндра Дармадала болой. Үүгээр ч тус хийгээд амгалан бүхэн гарах орны ялгуусан шашин ер хийгээд ялангуяа ялгуусан хоёрдугаар Лувсандагвын цогт номлол бүтээлийн шашин эрдэнэ зүг цаг бүхэнд дэлгэрч арвижин өнөд орших болтугай. Өлзий.

⁸⁹ yi-dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas-kyi lhan thabs gsal ba'i me-long las glegs bam bzhug bzhi-pa.

Resume

Luvsannorovsharav (1701-1768) was famous Mongolian religious figure and talented scholar of the 18th century. His Tibetan language work consisting of 7 volumes is not studied completely nowadays. In this article firstly we compared three kinds of indexes (tib. dkar chag, mon.garchag) of works of Luvsannorovsharav, in which are listed 54-60 titles of work. We numbered these indexes as A, B and C. The index A listed 54 works, index B-58, index C-60. The index C except listing titles of 60 works has verse of worship. As the colophons contain interesting facts about the life and activity of writers, secondly, we regard colophons of works of Luvsannorovsharav and attached its translation. The main content of colophon has following facts about

1. The reason of writing
2. The method of writing
3. The place of writing
4. The period of writing
5. The name of writer and copyist
6. The note on useful quality of these works as a reward for a meritorious action

Luvsannorovsharav wrote his work by some Mongolian lords request, which were real Buddhists and patrons. In the colophons are listed the names of these people. For composing his works Luvsannorovsharav used main sources of Tibetan Buddhist literature, the titles of which also mentioned in the colophon. The main place of writing was the lamasery Gedanshadduvdanpelva, where Luvsannorovsharav was served. The time of writing was not fully mentioned. But in the three works are mentioned years 1746, 1748, 1757. Luvsannorovsharav as a author writes his names differently as Chin sujigt (lit.true worshipper), Gungaarinchen. At the end of colophon Luvsannorovsharav expressed a wish for all creatures.